

2024 он 2 сар 8 өдөр

Дугаар 01/24

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 76 дугаар зүйлийн 76.1.12, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 2 сарын 8-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас 33.80% (гучин гурван зуун наян)-иар буюу 750,000,000 (долоон зуун тавин сая) төгрөгийн мөнгөн хэлбэрээр тооцож, нэгж хувьцаанд 30 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахыг зөвшөөрсүгэй.
2. Ногдол ашиг хүртэх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахтай холбоотой төлбөр тооцоог “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-иар зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2024 оны 8 сарын 28-ны өдөр олгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох гэрээ хэлэлцээр байгуулж гэрээнд гарын үсэг зурахыг Гүйцэтгэх Захирал (Г.Цогбадрах)-д даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор (П.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА



О. ОДБАЯР